



ЖИЛИЙН ТАЙЛАН

2021

Улаанбаатар хот



МОНГОЛ ДААТГАЛ



АЛСЫН ХАРАА

Даатгалын иж бүрэн үйлчилгээг айл өрх, албан байгууллага бүрт хүргэсэн дэлхийн жишиг компани байна



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагч төвтэй, мэргэшсэн, ёс зүйтэй даатгалын үйлчилгээг шилдэг шийдлээр хүртээмжтэй хүргэж итгэлтэй ирээдүйг бүтээлцэнэ



ҮНЭТ ЗҮЙЛС

Харилцагчийн сэтгэл ханамж

Мэргэжлийн өндөр ур чадвар

Шинийг санаачлах

Нийгмийн хариуцлага

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эх орныхоо тайван амгалан, иргэдийнхээ тав тухтай амьдрал, Монгол улсынхаа хөгжлийн төлөө өдөр бүр зогсолтгүй ажиллаж байгаа эрхэм хэрэглэгч Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе!

Монголын даатгалын салбарын үүсэл хөгжлийг эхлүүлсэн анхдагч компани “Монгол Даатгал” ХК-ийн хувьд өөрийн өргөн мэдээллийн бааз суурь, тогтвортой соёл, мэргэшсэн чадварлаг баг хамт олонд тулгуурлан Монгол улсын 21 аймаг дахь өөрийн салбар, даатгалын борлуулалтын хамгийн өргөн сүлжээ бүхий 600 гаруй төлөөлөгчөөрөө дамжуулан харилцагч төвтэй даатгалын үйлчилгээг санал болгон, цахимаар даатгалын үйлчилгээг хүргэн, тэдний хүсэл, хэрэгцээ, сэтгэл ханамжийг 7/24 цагаар зогсолтгүй сонсож, судлан, байнгын сайжруулалтыг хийж, 2021 оны байдлаар бидэнд итгэл хүлээлгэсэн даатгуулагчдын тоо 255 мянгад хүрч, жилээс жилд нэмэгдэн, санхүүгийн голлох үзүүлэлтээр тэргүүлж байна. Бид хөгжлөөрөө ямагт анхдагч, тэргүүлэгч байгааг хэлэхэд таатай байна. Түүнчлэн бид дэлхийд нэр хүндтэй, өндөр зэрэглэлтэй, тэргүүлэгч давхар даатгалын компаниудад эрсдэлээ шилжүүлснээр харилцагчиддаа давхар даатгагдсан хамгийн өндөр багцыг санал болгох боломжийг бүрдүүллээ.


Харилцагчидтайгаа хамтдаа хөгжүүлж буй бидний бизнес өдрөөс өдөрт өргөжин тэлж байгаа нь иргэд, байгууллагуудын даатгалын мөн чанар, ач холбогдлыг ойлгох ухамсар нэмэгдсэнтэй холбоотой. Гэсэн хэдий ч хүмүүний итгэлтэй ирээдүй, амар тайван амьдралын төлөө бидний итгэл үнэмшил цуцашгүй байж, даатгалын үйлчилгээг айл өрх, байгууллага бүрт хялбар, ойлгомжтой, хүртээмжтэй хүргэхэд тэмүүлсээр байх болно.

КОМПАНИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

Сайн засаглалын олон улсын шалгарсан практикуудыг нутагшуулж, засаглал, менежментийн эрүүл зөв тогтолцоог хэрэгжүүлэх нь Монгол Даатгалын эрхэм зорилгын чиглүүлэгч.


Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлснээр компанийн үйл ажиллагаа тогтвортой явагдах, бие даасан хараат бус, чанартай шийдвэр гаргалтуудыг хийх боломжийг бүрдүүлэхээс гадна цаашдын тасралтгүй өсөлт хөгжилтөд эерэгээр нөлөөлдөг.

Монгол Даатгал нь компанийн сайн засаглалын олон улсын шалгарсан зарчмуудыг хэрэгжүүлдэг бөгөөд эдгээрийг бодитой хэрэгжүүлснээр Монголдоо тэргүүлэгч даатгалын нэр хүндийг хадгалахаас гадна, үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой. Монгол Улсын тэргүүлэгч даатгалын компанийн хувьд бид компанийн засаглалын туршлагыг сайжруулж, эрүүл зөв тогтолцоог бий болгохын тулд компанийн засаглалын өнөөгийн түвшин, шаардлагатай өөрчлөлтүүдийг тодорхойлж, компанийн засаглалын бодлого журмыг боловсронгуй болгон ажиллаж байна.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2021 оны эхний хагас жилд улс орон даяар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон үед Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа цахимаар амжилттай зохион байгуулж хурлаар компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар танилцуулж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталлаа.



Хувьцааны арилжаа

Нийт гаргасан хувьцаа: 64,132,341
 Зах зээлийн үнэлгээ: 224,783,855,205.00
 Хаалтын ханш: 3,505

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Монгол Даатгалын Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь нийт есөн гишүүнээс бүрддэг бөгөөд гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас жил бүр сонгон томилдог.



Хувьцаа эзэмшигчид:

№	Нэр	Эзэмшиж хувьцааны хувь	Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал	Түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд
1	Миллиуним секюритиез	99.79 %	Байхгүй	Байхгүй
2	Бусад	0.21%		

ТУЗ-ийн гишүүд



Громов С.Б.
ТУЗ-ийн дарга
Громов Сергей Борисович нь 2001 оноос хойш банк санхүү, даатгалын салбарт ажилласан туршлагатай. Өнгөрсөн хугацаанд "Чингис Хаан" банкны ТУЗ-ын даргаар 2001-2016 он хүртэл, "Монгол Даатгал" ХК-д ТУЗ-ын даргаар 2004 оноос одоог хүртэл ажиллаж байна.



О.Цогт
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Очиржанцангийн Цогт нь Инженер эдийн засагч, татвар санхүүгийн чиглэлээр ОХУ, Япон улсад суралцсан бөгөөд Хүлэг консалтинг ТМЗ ХХК-д татварын зөвлөхөөр ажиллаж байна.



Д.Отгонбат
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Дашдаржээгийн Отгонбат нь Геологи хайгуулын өрөмдлөгийн технологийн менежер, СЭЗИС-ын бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. "Обзерв" консалтинг ЗУБ үүсгэн байгуулагч, ерөнхийлөгч, ОУ-ын удирдлагын тогтолцооны стандарт зөвлөгөө мэдээллийн төв ТББ-ын дарга ТУЗ-ын гишүүн, Ти Ай Си консалтинг ХХК-ийн үүсгэн байгуулагч, ерөнхий захирлаар ажиллаж байна.



Б.Энхтуяа
ТУЗ-ийн гишүүн
Бавуудоржын Энхтуяа нь эдийн засагч мэргэжилтэй, бизнесийн удирдлагын магистр, удирдахуйн ухааны доктор зэрэгтэй. ШУТИС-д тэргүүлэх профессор, салбарын эрхлэгчээр ажиллаж байгаа бөгөөд 2021 оны 12-р сараас эхлэн "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



Таня Лизунова
ТУЗ-ийн гишүүн
Таня Лизунова нь МУИС-д санхүү эдийн засгийн чиглэлээр суралцсан. 2006 оноос хойш Чингис Хаан банкны ТУЗ-ын туслахаар ажиллаж байсан бөгөөд 2016 оноос хойш "Монгол Даатгал" ХК-д ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.



Ц. Оюунжаргал
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Цэндбазарын Оюунжаргал нь эдийн засгийн ухааны бакалавр, магистр, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. Глобал стратеги удирдлагын институтын гүйцэтгэх захирлаар 2014 оноос хойш одоог хүртэл ажиллаж байна.



Б.Аюуш
ТУЗ-ийн гишүүн
Базарын Аюуш нь Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, эрхзүйч эдийн засгийн ухааны доктор зэрэгтэй. Мандах дээд сургуульд зөвлөх профессор, Райнос ассет менежмент компанид ахлах аудитороор ажиллаж байгаа бөгөөд 2021 оны 12-р сараас эхлэн "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



Огай Н.Ю.
ТУЗ-ийн гишүүн
Огай Наталья Юрьевна хэлзүйч, санхүүч мэргэжилтэй. ОХУ болоон Монгол улсад банк, санхүү, даатгалын чиглэлээр 2003 оноос хойш ажиллаж байгаа туршлагатай. "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2016 оноос одоог хүртэл ажиллаж байна.





О.Эрдэнэбулган
ТУЗ-ийн гишүүн
Очирбатын Эрдэнэбулган нь Санхүүгийн менежмент, Төрийн захиргааны менежментээр суралцсан магистр зэрэгтэй, санхүүч мэргэжилтэй. 2003 оноос хойш удирдах албан тушаалд ажилласан туршлагатай бөгөөд одоо "Монгол Даатгал" ХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

ЭДИЙН ЗАСАГ

2021 онд цар тахлын нөхцөл байдал үргэлжилж, шат дараалласан хөл хорионы арга хэмжээ авч хэрэгжүүлсэнтэй холбоотой МУ-ын эдийн засаг, салбаруудын үйл ажиллагаа тасалдсан, хил гаалийн хязгаарлалттай холбоотой нийлүүлэлтийн шалтгаантай инфляц өсч иргэдийн худалдан авах чадвар буурсан жил болж өнгөрлөө.

Эдийн засгийн өсөлтийг 5-6%-иар ОУ-ын байгууллагууд таамаглаж байсан хэдий ч 2021 онд идэвхжил саарч эдийн засаг 1.4%-ийн өсөлттэй гарсан байна. Эдийн засгийн өсөлт саарахад аж үйлдвэр, барилгын салбар 7%-иар /-1.0 пункт/ , Хөдөө аж ахуйн салбар 5.5%-иар /-0.8 пункт/ буурсан нь голлон нөлөөлсөн байна. Хил гаалийн хязгаарлалт, цар тахлын нөхцөл байдлын улмаас уул уурхайн салбарын экспортын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 2 дахин буурсан боловч түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ өндөр байсантай холбоотойгоор салбарын өсөлт 1.7% эдийн засгийн өсөлтөд /0.2 пункт/ эерэг нөлөө үзүүлсэн байна.


Эдийн засгийн салбаруудын өсөлт, бууралт 2021



Монгол орныг хамарсан ДААТГАЛЫН ӨРГӨН СҮЛЖЭЭ

Бид иргэд даатгуулагчдынхаа цагийг хэмнэж, ЭНГИЙН, ХЯЛБАР шийдлээр даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэж ажиллахаар цахим худалдан авалтын боломжуудыг өргөжүүлэн ажиллаж байна.






ДААТГАЛЫН САЛБАРЫН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Салбарын үзүүлэлт	2019	2020	2021
Нийт актив	366	382	354.5
Өөрчлөлт %	45%	4%	-7%
Нийт хураамжийн орлого	197	205	242.2
Өөрчлөлт %	12%	4%	18%
Даатгалын гүнзгийрэлт, хувиар	0.53%	0.55%	0.56%
Нөхөн төлбөр	64	55.8	67.4
Өөрчлөлт %	12%	-13%	21%


КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2021 онд нийт хөрөнгийн хэмжээ 37.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2.1 тэрбум төгрөгөөр, нийт хураамжийн орлого 27%-иар өсч 29.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд бид эрсдэлийн удирдлага, андеррайтингийн бодлогын хүрээнд гэрээний чанарыг сайжруулан, давхар даатгалд эрсдэлээ шилжүүлэн харилцагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж 8.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчдадаа олгож ажилласан байна.



КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Зах зээлд эзлэх хувь



Санхүүгийн үзүүлэлтүүд	2019	2020	2021	Өөрчлөлт
Нийт хураамжийн орлого	32,659	23,098	29,223	27%
Цэвэр хураамжийн орлого	21,536	16,364	15,595	-5%
Нийт нөхөн төлбөр	17,868	7,654	8,778	15%
Хөрөнгө оруулалтын орлого	1,510	1,166	3,001	157%
Нийт хөрөнгө	43,294	34,906	37,047	6%
Нийт нөөц сан	24,354	18,423	21,102	15%
Эздийн өмч	13,643	13,963	14,078	1%

Үзүүлэлт	2019	2020	2021
Хохирлын харьцаа	46%	45%	56%
Зардлын харьцаа	70%	68%	69%
Нийлмэл харьцаа	117%	113%	125%
Төлбөрийн чадвар	117%	119%	114%

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

Эрсдэлийн сонголтот тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүн нэвтрүүллээ.



КОВИД-19 ЫН ВАКЦИНЫ ЭРСДЭЛИЙН ДААТГАЛ

Вакцины эрсдэлийн даатгалын шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлэв.



ТАЛЫН 5 ЭРДЭНЭ

“Талын 5 Эрдэнэ” 2 малын индексжүүлсэн даатгал урамшуулалт аяныг 2 дахь жилдээ зохион байгуулж байна.



ДАВХАР ДААТГАЛЫН ГЭРЭЭГ ШИНЭЧЛЭВ

Трити давхар даатгалын гэрээний хамгаалалтыг шинэчлэн сайжруулсан.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Бид бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй сайжруулж, харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн энгийн, хялбар ойлгомжтой байдлыг тэргүүнд тавьж харилцагч төвтэй бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхээр зорьж байна.



КОВИД19-ИЙН ВАКЦИНЫ ЭРСДЭЛИЙН ДААТГАЛ

2019 оны сүүлээс эхэлсэн КОВИД-19-ийн цар тахал нь дэлхий дахинд тархаж хүн төрөлхтний амьдралд маш хүчтэй хор нөлөө үзүүлсээр байна. КОВИД-19-ийн эсрэг вакциныг богино хугацаанд гаргаж чадсан боловч вакцины үр нөлөөгүй байдлаас үүдэн дахин оношлогдох, өвчлөх, мөн вакцины гаж нөлөө үүсэх эрсдэл хэзээд байдаг тул "Монгол Даатгал" ХК энэ цаг үед тохирсон КОВИД-19-ийн вакцины эрсдэлийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүлсэн.



ЭРСДЭЛИЙН СОНГОЛТОТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛ

Даатгуулагч эрсдэлээ өөрөө сонгон даатгуулах боломжтой тээврийн хэрэгслийн болон эзэмшигчийн мэдээллээс хамаарсан итгэлцүүр ашиглан тооцоогдох хураамж бүхий шинэ тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүлсэн.

2021 ОНЫ НӨХӨН ТӨЛБӨРИЙН ЗАРИМ ТОХИОЛДЛУУД



Хохирлын хэмжээ: 70сая

Даатгалын төрөл:
Хөдлөх хөрөнгө болон бараа материалын даатгал

Объектийн гал түймэр УИД-т гарсантай холбоотой манай 2 харилцагчийн бараа материал, эд хөрөнгөд хохирол учирсан.



Хохирлын хэмжээ: 59сая

Даатгалын төрөл:
Үл хөдлөх хөрөнгийн даатгал

Даатгуулагчийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгөд цахилгаанаас үүдэлтэй гал гарч даатгуулагчийн өмч хөрөнгөд хохирол учирсан.



Хохирлын хэмжээ: 89сая

Даатгалын төрөл:
Хүнд машин механизмын даатгал

Уулын ажлын явцад мөргөцөг нурсны улмаас экскаватор унаж эвдэрсэн.



Хохирлын хэмжээ: 28сая

Даатгалын төрөл:
Ачаа тээврийн даатгал

Гадны нөлөөнөөс үүдэлтэй гал гарч цаас тээвэрлэж явсан даатгуулагчийн машин шатсан бөгөөд нийт 28 сая төгрөгийн нөхөн төлбөрийн ачаа тээврийн даатгалаар олгосон.

ДАВХАР ДААТГАЛЫН ТҮНШҮҮД

ДАВХАР ДААТГАЛ

Бид хүлээн авсан эрсдэлээ үнэлэн, шинжилгээ хийж, өөрийн төлбөрийн чадвар, эдийн засгийн чадавх, макро эдийн засгийн өөрчлөлт, хандлагатай уялдуулан дэлхийн томоохон, нэр хүндтэй давхар даатгагч нарт эрсдэлийн багцаа Трити болон факультатив байдлаар нэг бүрчлэн давхар даатгуулдаг.

Бид давхар даатгагчдын санхүүгийн найдвартай байдлыг нэн түрүүнд чухалчлан, санхүүгийн хүчин чадлын үнэлгээгээр A.M.Best “A-”, S&P “BBB”-ээс дээш үнэлгээтэй нэр хүнд бүхий зах зээлд тэргүүлэгч давхар даатгагчаар даатгуулдаг.

Манай факультатив давхар даатгалын эрсдэлийг Их Британи, Герман, Сингапур, Хон-Конг, Оросын холбооны улсад байрласан санхүүгийн хүчин чадлын зэрэглэл тогтоогч Standard & Poor’s, A.M.Best, Fitch-ийн өндөр үнэлгээ бүхий давхар даатгалын компаниуд хүлээн авдаг.

Дэлхийд нэр хүндтэй, өндөр үнэлгээтэй, томоохон давхар даатгагч нар нь манай эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэхээс гадна, харилцагчдад хамгийн найдвартай, өндөр түвшний даатгалын хамгаалалт болон түргэн шуурхай үйлчилгээ авах боломжоор хангаж байгаа юм.

Давхар даатгах нөхцөлүүд:

- 5 сая ам.доллар хүртэлх үнэлгээтэй даатгалын гэрээнүүдийг багцын давхар даатгалын гэрээний дагуу автоматаар хамгаалалтад багтана.
- Багцын давхар даатгалын хамгаалалтаас давсан өндөр үнэлгээ бүхий эсвэл онцгой төрлийн үйл ажиллагаа явуулдаг харилцагчидтай факультатив давхар даатгалын гэрээг байгуулна.
- Олон улсын эрүүл мэнд, гадаад зорчигчдын гэнэтийн ослын даатгалын үйлчилгээг дэлхийн нэр хүндтэй, даатгалын зах зээлд тэргүүлэгч давхар даатгалын компаниуд Allianz Worldwide Care, Hannover Re, болон Ocean Re-тай хамтран харилцагч нартаа хүргэж байна.

Бид хүлээн авсан эрсдэл бүртээ шинжилгээ хийж шаардлагатай тохиолдолд давхар даатгалын хамгаалалтаар бүрэн хангаж харилцагчдынхаа найдвартай түнш байх зорилгоо тогтмол биелүүлсээр байна.



ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




Бид харилцагчдадаа эрсдэл тулгарсан, эрсдэлээс хамгаалах аль ч үед нь ойр байж боломжит харилцааны бүх сувгуудаар дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэхийг зорьж ажилладаг.

2021 онд Лавлах төвийн утсанд нийт 39,124 дуудлага ирсэн байна.

	Шуурхай алба, ослын дуудлага	46%
	Даатгал, бүтээгдэхүүнтэй холбоотой	34%
	Нөхөн төлбөрийн үйлчилгээтэй холбоотой	18%
	Санал хүсэлт	2%

CHATBOT

Монгол Даатгалын цахим туслах /Chatbot/ мессенжерт хандсанаар **Та даатгалын мэдээлэл зөвлөгөө болон даатгалын үйлчилгээ авах, гэрээ сунгах болон нөхөн төлбөрийн явцаа** харах боломжтой.



Даатгалын үйлчилгээ



Даатгалын тохиолдолын зураг илгээх



Нөхөн төлбөрийн явц шалгах



Нөхөн төлбөрийн бүрдүүлэх материал



Хаяг байршлын мэдээлэл



Даатгалын бүхий л төрлийн зөвлөгөө



ТҮҮХЭН ТОВЧОО

Монгол Даатгал ХК нь 1934 онд “Улсыг аюулаас хамгаалах газар” хэмээн Сангийн Яамны салбар нэгж болон тулгын чулуугаа тавьж үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй. Эдүгээ нэгэн наяны турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, гадаад дотоодын түнш байгууллага, ард иргэддээ даатгалын үйлчилгээг тасралтгүй хөгжүүлэн хүргэж байгаа билээ.

2021
Гэгээ Эрүүл мэндийн даатгалын брэндийг бүтээлээ

2020
“Монгол Даатгал” компани нээлттэй хувьцаат компани боллоо.

2019
Үйлчилгээний бодлогоо орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн шинэчилж логогоо ЭНГИЙН, ХЯЛБАР, УХААЛАГ шийдлийг тусгалаа.

2018
“Буухиа хүү” мобайл аппликейшныг даатгалын салбарт анхлан гаргав.

ISO 9001:2015 ЧУТ-ны батламжаа хоёр дахь удаагаа баталгаажууллаа.

Харилцагчдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн салбартаа анхлан ЦАХИМ ДААТГАЛЫН үйлчилгээг нэвтрүүллээ.

2014
Global Banking and Finance Review байгууллагаас Монгол улсын шилдэг Даатгалын компани –аар шалгаруулав.

2016
Даатгалын салбарт анх удаа ISO 9001:2015 ЧУТ-г хэрэгжүүлж эхэллээ.

2017
Утсан даатгалын үйлчилгээг анхлан нэвтрүүлэв.

2017
ISO 9001:2015 ЧУТ-ны баталгаажуулалтын гэрчилгээгээ гардан авлаа.

Allianz world wide care компанитай хамтын ажиллагааг эхлүүлэв.

1974
ОУ-ын болон гадаадын байгууллагын барилга байгууламж, тээврийн хэрэгслийн заавал даатгалыг хийж эхэллээ.

1964
“Нэгдэл хоршооллын мал сүрэг, САА-н таримал ургамлын заавал даатгал”-ыг анхлан хийв. ОУ-ын брокер болон давхар даатгагч нартай хамтран ажиллаж эхэллээ.

1962
Улсыг аюулаас хамгаалах газар нь Улсын даатгах газар нэртэй болж өөрчлөгдөв.

1961
ХАА-н нэгдлийн тариалангийн даатгал нэвтрүүлээ.

1947
“Тээврийн хариуцлагын заавал даатгал” хийж эхлэв.

1953
Зорчигчийн амь насны даатгал гаргав.

1949
Бөмбөгөр ногоон театрын хохирлыг барагдуулав

1959
Хоршооллын байгууллагын эд хөрөнгийн заавал даатгал нэвтрэв.

1949 он Бөмбөгөр ногоон театр нь Монгол Даатгал компанид даатгалтай байсан бөгөөд нийт 3 удаагийн гал гарч үүссэн хохирлыг тус тус нөхөн олгосон байна.



2006
Монголд анх удаа 7/24 шуурхай дуудлагын албатай болов.

2010
Олон улсын давхар даатгалын зах зээлийн томоохон давхар даатгагч болох “HANNOVER RE” компанитай хамтран ажиллаж эхэллээ.

2011
Даатгалын салбарт анх удаа өндөр хамгаалалттай олон улсын эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлэв.

2012
Банкашурансыг Монголд хөгжүүлэхээр дотоодын арилжааны банкнуудтай хамтран ажиллаж эхлэв.

2005
Дэлхийн банкны төслийн хүрээнд “Малын индексжүүлсэн даатгал” –ын борлуулагчаар ажиллаж эхлэв.

2003
Монгол Даатгал ХК хувьчлагдав.

1994
Монгол Даатгал ХК-ийн ажилтнууд оролцон боловсруулсан Даатгалын тухай Монгол улсын хууль хэлэлцэгдэн батлагдав.

1990
Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрт шилжив.

1934
Монгол Даатгал ХК-ийн суурь тавигдаж, анхны даатгалын үйл ажиллагааг эхлүүлэв.

1935
ЗХУ-ын Госстрах даатгалын газартай хамтран давхар даатгалын үйл ажиллагааг эхлүүлээ.

1936
“Албан байгууллага, аж ахуй нэгжийн даатгал” үйлчилгээг анх нэвтрүүлэв.

1946
Хувь хүн болон ажилтнуудад зориулсан амьдралын даатгалын бүтээгдэхүүн гаргав.

Монгол Даатгал ХК-ийн суурь тавигдаж, анхны даатгалын үйл ажиллагааг эхлүүлэв.

БИДНИЙГ СОНГОХ ШАЛТГААН



САЛБАРЫН ТЭРГҮҮЛЭГЧ

88 жилийн түүхтэй "Монгол Даатгал" ХК нь салбарын анхны компани, ололт амжилтуудыг бүтээж ажиллагдийн хувьд өөрийн өргөн мэдээлэл, технологийн дэвшлүүдийг ашиглан харилцагчдынхаа эрсдэлд бодитой үнэлэлт өгөх туршлагатай байж хэрэглэгчдийн тэргүүн сонголт байсаар ирлээ.



ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ТЭРГҮҮЛЭГЧ

Харилцаа итгэлцэлд суурилдаг манай бизнест бид харилцагчийнхаа санал хүсэлтийг 7/24 цагаар хүлээн авч шуурхай шийдвэрлэн, эрсдэлийн төрөл бүрийн сургалт зөвлөгөө өгөх зэргээр харилцагчдыг эрсдэлээс хамгаалахад бүх талаар анхаарал хандуулан тэдний сэтгэл ханамжийг эрхэмлэж ажилладаг.



БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ

Даатгалын зах зээлд ёс суртахууны өндөр хэм хэмжээнд мэргэжлийн төвшинд эрсдэлийн удирдлагын зөвлөгч байж, олон улсын жишигт хүрсэн үйлчилгээг үзүүлэн, тэдний санхүүгийн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж, гэрээгээр хүлээсэн үүргээ нэр төртэйгээр биелүүлэн ажиллаж байна.



ДАВХАР ДААТГАЛ

Бид хүлээн авсан эрсдэлээ үнэлэн, шинжилгээ хийж, өөрийн төлбөрийн чадвар, эдийн засгийн чадавх, макро эдийн засгийн өөрчлөлт, хандлагатай уялдуулан дэлхийн томоохон, нэр хүндтэй давхар даатгагч нарт эрсдэлийн багцаа Трити болон факультатив байдлаар нэг бүрчлэн давхар даатгуулдаг.



САНХҮҮГИЙН ЧАДАМЖ

Даатгалын зах зээл дэх хамгийн том нөөц сангийн хамгаалалт болон нөхөн төлбөр олголт, зах зээлд эзлэх хувиар санхүүгийн бүхий л үзүүлэлтээр салбартаа тэргүүлэгч байхаас гадна 12,5 сая ам.доллар хүртэлх үнэлгээтэй даатгалын гэрээнүүдийг олон улсад нэр хүндтэй, давхар даатгалын компаниудаар багцын давхар даатгалын гэрээний дагуу харилцагч бүрийг автоматаар хамгаалалтад авдаг.



ДААТГАЛЫН ӨРГӨН СҮЛЖЭЭ

Монгол улсын 21 аймаг, Нийслэл хотын дүүрэг бүрт байрласан 33 салбар нэгж, 600 гаруй мэргэшсэн даатгалын төлөөлөгч бүхий даатгалын борлуулалтын хамгийн өргөн сүлжээгээр дамжуулан харилцагчиддаа үйлчилдэг.



НӨХӨН ТӨЛБӨРИЙН БОДИТ БАТАЛГААЖУУЛАЛТ

Эрсдэлийг цаг алдалгүй баталгаажуулахыг зорилгоо болгож салбартаа хамгийн өргөн бүрэлдэхүүнтэй мэргэшсэн шуурхай албыг 7/24 цагаар Улаанбаатар хотын 4 цэгт байрлуулан ажиллаж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН & ҮЙЛЧИЛГЭЭ

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ДААТГАЛЫН ХЭЛБЭРҮҮД



Гэнэтийн осол, эмчилгээний даатгал



Хөрөнгийн даатгал



Автотээврийн хэрэгслийн даатгал



Хүртээмжтэй даатгал



Мал, амьтдын даатгал



Жолоочийн хариуцлагын даатгал

БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН ДААТГАЛЫН ХЭЛБЭРҮҮД



Гэнэтийн осол, эмчилгээний даатгал



Хөрөнгийн даатгал



Автотээврийн хэрэгслийн даатгал



Ачааны даатгал



Итгэлцлийн даатгал



Агаарын хөлгийг өмчлөх эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал



Хариуцлагын даатгал



Газар тариалангийн даатгал



Агаарын хөлгийн даатгал



Барилга угсралтын даатгал



Санхүүгийн даатгал

ЗӨВЛӨГӨӨ, ҮЙЛЧИЛГЭЭ



ГАМШГИЙН МЕНЕЖМЕНТИЙН СУРГАЛТ ЗӨВЛӨГӨӨ:

Бид гэнэтийн эрсдэл, аюул, ослын үед учирч болзошгүй хохирлыг бууруулахад даатгуулагчиддаа өөрийн мэргэжлийн боловсон хүчин, Улсын Онцгой байдлын газар болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран практик сургалт зохион байгуулдаг. Тухайлбал, бид энэ чиглэлд АНУ, Япон, Орос зэрэг өндөр хөгжилтэй улсын мэргэжлийн байгууллагыг урьж сургалт зохион байгуулж байсан туршлагатай.



ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ:

Орчин үеийн хэрэглэгчдийн хэрэглээ вэб сайт, Фэйсбүүк мессенжер твиттер, инстаграмаар дамжуулан харилцагчиддаа мэдээлэл хүргэн, санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэж, даатгалын үйлчилгээг улам ойртуулан ажиллаж байна.



ДААТГАЛЫН ХУГАЦААНЫ МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ҮЙЛЧИЛГЭЭ:

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний хугацаа дуусах тохиолдолд тухай бүрт нь дуут мессеж илгээж гэрээний сунгалтыг бүх салбар нэгжээрээ дамжуулан хийж байна.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗӨВЛӨГӨӨ:

Аливаа бизнест тулгарах алдагдал, хохирол, хор хөнөөлөөс сэргийлэхийн тулд эрсдэлийг эрт илрүүлж, удирдах нь чухал байдаг. Иймээс бид харилцагчдынхаа эрсдэлийг илрүүлж, бодитой үнэлснээр түүнийг бууруулах, үр дүнтэй удирдахад нь ямагт онцгой анхаарал анхаарал хандуулж холбогдох ажилтнуудад “ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЦОГЦ СУРГАЛТ”-ыг зохион байгуулдаг.



МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Бид харилцагчдынхаа бизнесийн эрсдэлийг цаг алдалгүй тооцоолох, удирдахад өөрсдийн өргөн мэдээллийн зэрэгцээ судалгааны мэргэжлийн байгууллагатай хамтран тухайлсан салбаруудын эдийн засгийн нөхцөл байдал, хандлагыг судлан цогц хэлбэрээр мэдээлэл өгч ажилладаг.



НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид харилцагчийн нөхөн төлбөрийн хүсэлт ирснээс хойш манай нөхөн төлбөрийн тусгай баг тухайн осол, эрсдэлийг газар дээр нь өөрийн болон мэргэжлийн багийн үнэлж баталгаажуулсныг үндэслэн нэхэмжилсэн мөнгөн дүнгээсээ хамааран ажлын 1-5 хоног, өндөр дүнтэй тохиолдолд хамтын гэрээний дагуу нөхөн төлбөрийг шуурхай шийдвэрлэн олгодог.



ДААТГАЛЫН ЛАВЛАХ УТАС

Бид өөрийн даатгалын лавлах 1800-1990 дугаарын утсанд ослын шуурхай дуудлага хүлээн авах, даатгалын мэдээлэл зөвлөгөө өгөх, харилцагчийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйлчилгээг долоо хоногийн 24 цагаар хүргэж байна. Харилцагчийн санал гомдлыг хүлээн авч ажилласнаар бид үйл ажиллагаандаа шаардлагатай тохиолдолд сайжруулалт хийж харилцагчдынхаа хүсэл хэрэгцээнд нийцүүлэн ажиллаж байна.



ШУУРХАЙ АЛБАНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Манай Шуурхай алба нь ослын дуудлага хүлээн авснаас хойш орчин нөхцөл өөрчлөгдөхөөс өмнө очиж, хохирлыг баталгаажуулах зорилгоор долоо хоногийн 24 цагаар Улаанбаатар хотын замын ачааллаас хамааран дөрвөн цэгт хуваагдан ажиллаж байна. Бид Шуурхай албаны ажилтнуудынхаа ур чадвар, мэдлэгт онцгой анхаарч харилцагчийн хохирлыг бодитой үнэлэхэд байнга мэргэшүүлж ажилладаг юм.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА 2021

Даатгалын бизнесийн мөн чанар нь нийгэмдээ чиглэсэн буюу аливаа эрсдэл учирсан үед тулгарч болох санхүүгийн эрсдэлээс хамгаалдаг боловч бид даатгалын боловсролыг багш сурган хүмүүжүүлэгчид, ирээдүйн бяцхан харилцагчдаа олгох, мэдлэгийг нэмэгдүүлэх, одоо байгаа харилцагчдаа эрсдэлээс хамгаалах зорилгоор дараах хамтын ажиллагааг хэрэгжүүлэн нийгмийн хариуцлагаа биелүүлэн ажиллаа.



“ДУРААРАА БИШ ЭЭ! ДҮРМЭЭРЭЭ” АЯН 2

ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Оюу толгой, Мобиком болон "Монгол Даатгал" ХК, хамтран хэрэгжүүлсэн зам тээврийн аюулгүй байдлын талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх “ЯАРААД ЯАХАВ ДЭЭ-2” арга хэмжээг 2 дах жилдээ хамтран зохион байгуулав.

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД НЭГДЭВ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум Мод” үндэсний хөдөлгөөнд “Монгол Даатгал” ХК-ийн хамт олон нэгдэж Сонгинохайрхан дүүргийн, 24 дүгээр хороо, Баруун салаа, Бумбатын булагт 3 төрлийн 80 гаруй суулцагч энэ үеэр тарьжээ.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ

1000 багш төслийг ивээн тэтгэж, Монгол орон даяар багш, сурган хүмүүжүүлэгч нийт 20,000 багш болон нийгмийн ажилтнуудад даатгалын үйлчилгээний талаар суурь ойлголтыг тус хөтөлбөрөөр дамжуулан хүргэж дэлхийн түвшний менежерийн сургалтад хамруулж өөрийн брэндийн хувь нэмрийг оруулав. ажиллагаа хийсэн.

ЦАХИМ СУВАРГА

Монгол орны биет бус өв соёл, дурсгалт газар, мартагдсан уламжлалыг сэргээн хөгжүүлж дэлгэрүүлэх, нийтэд таниулан сурталчлах томоохон төсөлд төслийн багийн бүхий л эрсдэлийг нь хариуцаж өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээ давуу талыг танилцуулсан.

“ДУДУ МАШИН ТББ”

Дүдү тоглоомын машинаараа хүүхэд багачуудад танигдсан, Дүдү боловсролын сан НҮТББ-тай хамтын ажиллагааны байгуулж очны эрсдэл, тээврийн хэрэгслийн эрсдэл, даатгалын үйлчилгээний онцлог, давуу талыг хүүхэд багачууд эцэг эхчүүдэд таниулан мэдүүлэх зорилготой хамтран ажиллав. Үүнд:

- Бүтээлч хайрцаг: Монгол Даатгалын логог байршуулж танилцуулгыг хавсаргасан.
- Дүдү тэмцээн: Дүдү машины уралдаан тэмцээнд даатгалын булан бүтээж нөхөн төлбөрийн үйлчилгээ үзүүлсэн.

ХАРИЛЦАГЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ



Даатгалын лавлах: **1800-1990**
Буухиа даатгал: **7010-1990**



Цахим хаяг:

Цахим хуудас: www.mongoldaatgal.mn
Цахим хаяг: insurance@mongoldaatgal.mn
Facebook: [/mongoldaatgal](https://www.facebook.com/mongoldaatgal)
Twitter: [/mongoldaatgal](https://twitter.com/mongoldaatgal)



Төв байр:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо,
Үндсэн хуулийн гудамж 32